

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-7
<b>1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал</b>	3-4
<b>2. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл</b>	4-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны 4 дүгээр сарын 01-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баярмаа;

Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, Б.Баярбаатар, Л.Мөнхбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал, Ц.Туваан, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг Зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулав.

**Ж.Бат-Эрдэнэ:** 1.Монгол Улсын Засгийн газраас 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 3 гишүүнээс 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 3 гишүүнээс 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 5  
Бүгд: 16  
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

*Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Ж.Бат-Эрдэнэ:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12  
Татгалзсан: 4  
Бүгд: 16  
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 81.3 хувиар Байнгын хорооны тогтоол батлагдлаа..*

*Уг асуудлыг 10 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 13 минут үргэлжилж, 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 10 цаг 39 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 26 минут

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Ж.Бат-Эрдэнэ:** Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Ингээд байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя. Оюунсайханы Алтангэрэл, Сандагийн Бямбацогт, Сархадын Зулпхар, Эрдэнэбилэгийн Одбаяр, Гончигдоржийн Уянгахишиг, Жадамбын Бат-Эрдэнэ, Лувсаннъямын Гантөмөр, Одсүрэнгийн Номинчимэг, Бөхчулууны Пүрэвдорж, Өлзийхүүгийн Шижир, Энхбатын Болормаа, Тогмидын Доржханд, Нямтайширын Номтойбаяр, Цэндийн Сандаг-Очир, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан зэрэг гишүүд хүрэлцэн ирсэн тул Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 4 дүгээр сарын 1-ний хуралдааныг нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцэх эсэх асуудал.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**1.Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5.7-д энэ хуулийн 5.1-д заасан жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг зөвлөлийн саналыг харгалзан Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол чуулганаар хэлэлцүүлнэ гэсэн ийм заалт байгаа. Ингээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төсөл бүрээр санал хураалт явуулъя.

1.Засгийн газраас 2025 оны 3 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны

дагуу чуулганаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцож, 68,8 хувиар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 3 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д хэсэгт заасны дагуу чуулганаар хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал 68,8 хувиар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 3 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу чуулганы хэлэлцүүлгийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 68,8 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төслүүдийг чуулганы хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

10.30 цаг.

Дараагийн асуудал.

**“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Тогтоолын төсөл. Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3-д хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн цэцийн дүгнэлтийг Улсын Их хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулна гэсэн байгаа. Энэ Цэцийн дүгнэлтийг 3 сарын 27-нд Улсын Их Хурал хүлээж авсан.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол. Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос тогтоох нь:

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн

2025 оны 03 дугаар дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тул Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох хэсэгт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн,

Ажлын хэсгийн гишүүн Б.Батбаатар Улсын Их Хурлын гишүүн, О.Номинчимэг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг, Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир нар.

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсгийн хэсэг /Ц.Сандаг-Очир/-т зөвшөөрсүгэй.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулт байна уу. Сандаг-Очир, Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Ийм ажлын хэсэг гарч байгаа юм байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ бас нэг зүйлийг хэлэхгүй бол сүүлийн Үндсэн хуулийн цэцийн 1, 3 дугаар дүгнэлт гээд 2 дүгнэлтийг хэлэлцсэн.

Тэгээд мэргэжлийн Байнгын хороо, манай Байнгын хороо ингээд 1 дүгнэлтийг нь хүлээж авна, нөгөөдхийг нь хүлээж авахгүй гэдэг ийм шийдвэр гаргасан. Гэтэл чуулган дээр очоод яг эсрэгээрээ хүлээж авна гэж Байнгын хороо үзэж байхад чуулган дээр очиж унасан, хүлээж авахгүй гэсэн шийдвэр маань Байнгын хороон дээр очиж дэмжигдсэн гээд эсрэгээрээ чуулган дээр Байнгын хорооны шийдвэр эсрэгээрээ гараад байгаа юм. Тэгээд Байнгын хорооны гишүүд маань юуны өмнө одоо бас өөрийнхөө Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороо дээрээ гаргасан шийдвэрээ бас чуулган дээр хамгаалдаг байгаач ээ гэдгийг нэгд хэлэх гэж байгаа юм.

Тэрнээс болоод саяын сүүлийн Үндсэн хуулийн цэцийн 1, 3 дугаар дүгнэлт бол улс төрийн маш том үр дагавартай шийдвэрүүд байгаа. Одоо та бид нартай бүгдтэй чинь холбоотой. Одоо энэ ажлын хэсэг дээр цэцийн 3 дугаар дүгнэлт бол сонгуулийн жил эхэлснээс хойш Улсын Их Хурлын гишүүд ямар ч тайлан, уулзалт хийж болохгүй, хэвлэмэл материал тайлан тарааж болохгүйгээр ингээд ийм гомдол байсан, энийг хүлээгээд авчихсан.

Манай Төрийн байгуулалтын байнгын хороо авахгүй гээд ингээд шийдвэр гаргасан шүү дээ. Гэтэл чуулган дээр очоод хүлээж авъя гээд ингэчихсэн. Тэгэхээр одоо энэ хуулиараа 15 хоногийн дотор хүлээж авсантай холбогдуулж хуулийн төслийг нийцүүлж оруулж ирэх ёстой юм байна. Тэгэхээр манай Байнгын хороонд харьяалагдаж байгаа улс төрийн намуудын төлөөллүүд энэ ажлын хэсэгт орсон байна.

Тухайлбал Батбаатар гишүүн Иргэний Зориг ногоон нам, Уянгахишиг гишүүн, ХҮН нам, Ардчилсан намаас Шижир гишүүн. Ингээд бид 5 ажиллах юм байна.

Тэгэхээр хугацаа их богино. Тэгэхээр та бүхэн бас намууд дээрээ, бүлэг дээрээ яриад энэ асуудлын гарц гаргалгаа юу байж болох вэ. Уг нь бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил шүү дээ. Энэ цэцийн дүгнэлтээр үзвэл үндсэндээ 3,6 жил болох нь байна шүү дээ. 6 сард нь сонгуулийн жил 1 сарын 1-ээс эхлээд огт уулзалт хийж болохгүй, тайлан тавьж болохгүй, хэвлэмэл материал тарааж болохгүй ийм Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээгээд авчихсан.

Энэ дээрээ та бүхэн нэг жоохон ач холбогдол өгөөд, ямар гарц гаргалгаа байж хуульд нийцүүлж энэ Цэцийн дүгнэлтээ нийцүүлж хуулиа өөрчлөх вэ гэдгээ хэдүүлээ бас бүлэг дээрээ ч, ажлын хэсэг дээрээ ч бас ажлын хэсэгт орсон гишүүдээрээ дамжуулж бүлгээсээ бас ярилцаж чиглэл өгөөрэй гэдгийг хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Сандаг-Очир гишүүн санал хэллээ. Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би түрүүчийн нөгөө хаврын чуулганаар хэлэлцэх асуудалтай холбоотой үг хэлэх гэж байгаад хоцорчихлоо. Дараагийнх дээ юм болгосон чинь. Тэгэхээр одоогийн байдлаар миний 5 хууль өргөн барихад бэлэн болчихсон байгаа.

Тэр нь бол НӨАТ-ын татварыг 5 хувь болгох хуулийн төсөл байгаа.

Хоёрдугаарх нь бол Онцгой татварын тухай хуульд өөрчлөлт оруулах буюу хуурамч шатахууны эсрэг хууль байгаа.

Гуравдугаарх нь Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого бичиг баримтын өөрчлөлт оруулах тогтоолын төсөл байгаа. Тэгээд би энэ хууль, тогтоолын төслүүдээ өргөн барихаар хүсэлт гаргасан. Гэвч Их Хурлын дарга хууль дээр чинь ярина гэдэг ийм байдлаар асуудалд хандаж байна. Миний хуулийг авахгүй юм байна л даа. Засгийн газар таны хууль дээр маань өөр байр суурьтай, эсрэг байр суурьтай байсан. Энэ бол тэрнээс үл хамааран миний эрхэнд байдаг. Өөрөөр хэлбэл өнгөрсөн 4 жилийн хугацаанд би нийтдээ 27 хууль өргөн барьсан. Тэр дээр бүгд дээр нь Засгийн газар эсрэг байр суурьтай байсан. Гэвч 8 хууль, 3 тогтоолын төсөл батлагдсан байгаа. Тэгээд ингээд хууль өргөн барих тэр хүсэлтийг минь хүлээж авахгүй цааргалсан байдалтай. Дээрээс нь яах вэ, тэр хуурамч шатахууны эсрэг хууль бол Ардын намынхны өнгөрсөн хугацаанд идэж уусан ...

**Ж.Бат-Эрдэнэ:** Пүрэвдорж гишүүн ээ, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой юу наадах чинь.

**Б.Пүрэвдорж:** Үгүй ээ, би хэлэлцэх асуудлаа ярьж байна шүү дээ. Тийм учраас ийм хууль байгаа. Дээрээс нь НӨАТ-ын татварыг 5 хувь болгох хууль бол ард түмэнд тун чухал хэрэгтэй. Ард түмний амьдрал хүнд хэцүү байж байхад энэ хуулийг хүлээж авахгүй ингэж хойшлуулж, хойш нь татна гэдэг бол бас асуудалтай. Тийм учраас уг нь бол өнөөдөр энэ асуудлыг оруулаад хэрвээ өргөн барьчихсан бол хуулиудаа хэлэлцүүлээд явах тэр боломжийг нь бас хааж байгаад харамсаж байна гэдгээ хэлье.

**Ж.Бат-Эрдэнэ:** Хуулиа өргөн бариарай. Асуулт асууж дууслаа. Санал хэлэх гишүүд байна уу. Алга байна. Бас санал хэлэх юм биш үү.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 16 гишүүн оролцож, 12 гишүүн дэмжиж 75 хувиар санал дэмжигдлээ.

Пүрэвдорж гишүүн дэмжсэн юм байна. Протоколд оруулчихъя.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа гишүүд ээ.

10.39 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*